



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/966

Мандаалговь

Г Гадаад арга хэмжээнд оролцуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "з" дэх заалт, Дундговь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.15 болон 1.1.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг дарга Л. Өлзийбат, Засаг даргын Тамгын газрын дарга Б. Энхтуяа нарыг Бүгд Найрамдах Итали Улсын Турин хотноо 9 дүгээр сарын 24-нээс 28-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Тогтвортой хөгжлийн зорилтуудад Зохистой хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан хүрэх нь" сэдэвт олон улсын сургалтанд оролцуулсугай.

Хоёр. Уг арга хэмжээнд төлөөлөгчийг оролцуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

488310149